

## “Монголын нууц товчоо” 8144 үгтэй



### Б.БАТДОРЖ

Монгол бол толь бичиг зохиох нэн эртний уламжлалтай орон. XIII зуун, тухайлбал, 1282 онд монгол үйгур үсгээр бичсэн нэвтэрхий толь бичгийг хэвлэж байсан түүхтэй. Энэхүү нэвтэрхий толь уламжлан ирээгүй хэдий ч, Монголын нууц товчоо /1240 он/ хэмээх алдарт бүтээлийг бид өвлөн авсан.

Нууц товчоо бол өмнөө их үндаргатай, хойноо олон дагуултай оргил бүтээл. Энэ

удаа “Монголын нууц товчоо бол Монгол түмний гал голомтын алтан хөшөө мөн” /Ерөнхийлөгч Н.Энхбаяр/ гэсэн өрлөг үгтэй “Монголын нууц товчооны толь” хэвлэлтээс гарав.

Уг тольд Нууц товчооны бүх үгсийг монгол, ром, шинэ үсгээр толгойлон оруулсан нь судлаачаар зогсохгүй, түмэн олын” хэрэглэхэд дөхөм хялбар болжээ. Төлийн дэлгэрэнгүй орчимд “Юан” гэдэг үгийн гарлыг мөшгин тайлбарлаж, Нууц товчоог 8144 үгтэй гэж тооцоолон гаргаснаас гадна Монголын нууц товчоог “элэг шиг эмзэг бодьгал цогцос” гэж тодорхойлоод, түүнийг хэрхэн засварлаж хайрцаг тогтолоог нь задэж сэтгүүлсэн тухай сонин баримтуудыг дэлгэсэн байна.

Хэл зохиолын хүрээлэнгийн эрдэм шинжилгээний тэргүүлэх ажилтан, профессор Б.Сумъяабаатар нарын эл толь бичиг 920 хуудастай бөгөөд “Бэмби сан” хэвлэлийн газар 200 ширхэг хэвлэжээ.